БНМАУ-ын ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 3р сарын 26-ны өдөр

Дугаар 139/83

Улаанбаатар хот

**Нийслэл хот дахь эрүүл мэндийн зарим байгууллагуудын зохион байгуулалтыг шинэчлэн өөрчлөх тухай**

Нийслэл хот дахь Эрүүл мэндийн албаны нэгж байгууллагуудын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үйлчилгээний шат, дамжлага, давхардлыг арилгах, хөдөлмөрчдийн чирэгдлийг багасгах, эмнэлэг-ариун цэврийн тусламжийн хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн яам, Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргаанаас ШИЙДВЭРЛЭЭН НЬ:

I. БНМАУ-ын орон нутгийн Ардын хурлын болон улсын төсвийн эрхийн тухай хуулийг үндэслэн Эрүүл мэндийн яамны шууд харьяа улсын үйлчилгээтэй эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагуудыг энэ оны IY сарын I-нээс эхлэн Улаанбаатар хотын харьяалалд шилжүүлж хот, хөдөөгийн үйлчилгээтэйгээр бие даалган ажиллуулсугай.

2. Нэгдсэн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв эмнэлгүүдийн бие даасан байртай поликлиникуудыг IY сарын I-нээс "Нарийн мэргэжлийн төв" дүүргүүдийн эрүүл мэндийн "Зөвлөх төв", дэвсгэр нутгийн Эрүүл мэндийн "төв" болгон бие даалган зохион байгуулж, дүүргийн сүрьеэ, арьс өнгөний диспансер, халдвартын клиникийн эмнэлэг, сэтгэц мэдрэлийн эмгэг судлалын нэгдсэн төвийн дүүрэг хариуцсан тасаг кабинетуудыг Эрүүл мэндийн зөвлөх төвүүдэд шилжүүлж ажиллуулсугай.

3. Дүүргүүдийн Ариун цэвэр, халдвар судлалын станцыг хотын Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын газрын салбар болгон ажиллуулсугай.

4. Улаанбаатар хотын Эрүүл мэндийн газрын дүрмийг I, Эрүүл мэндийн төвүүдийн ажиллах журмыг II, нийслэл хот дахь эрүүл мэндийн зарим байгууллагуудын шинэчлэн тогтоосон нэршлийг III, клин-

никийн нэгдсэн эмнэлгүүдийн нарийн мэргэжлийн чиглэлийг IY, хотын нутаг дэвсгэрт эрүүл мэндийн төв барьж байршуулахад баримтлах хот төлөвлөлтийн нормативыг Y хавсралтаар тус тус батласугай.

5. Улаанбаатар хотын дүүргүүдийн Ардын хурлын гүйцэтгэх захиргааны Эрүүлийг хамгаалах, нийгэм хангамжийн хэлтсийг 4 дүгээр сарын I-нээс татан буулгаж, бүх орон тоо цалингийн санг нь дүүргүүдийн эрүүл мэндийн зөвлөх төвүүдэд шилжүүлсүгэй.

6. Хотын хүн амын эрүүл мэндийн байдалд дүгнэлт хийж бодлого боловсруулах үндсэн үүрэгтэй орон тооны бус "Нэгдсэн зөвлөл"-ийг дүүргүүдийн эрүүл мэндийн "зөвлөх төв"-ийг түшиглэн байгуулж ажиллуулсугай.

7. Хотын Эрүүл мэндийн газар /н.Буян-Өлзий/, Боловсролын удирдах газар /н.Чимэддорж/-т ДААЛГАХ НЬ:

а/ хотын 3,4,I9,20,23,29,32,40,41,42,44,45 дугаар яслиудыг архаг өвчтэй хүүхдийг эрүүлжүүлэх сувиллын ясли болгож бусад яслиудыг байршлаар нь нэгтгэх, боломжоотой зарим яслид цэцэрлэгийн анги нээж 3 настай хүүхдүүд авч хүмүүжүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авах,

б/ их, дээд, тусгай мэргэжлийн дунд, техник мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, цэцэрлэг-яслийн комбинатын их, бага эмч, сувилагчдын мэргэжлийг дээшлүүлэх эмчилгээ, үйлчилгээний ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих асуудлыг Эрүүл мэндийн төвүүдэд хариуцуулж ажиллуулах.

8. Хотын түргэн тусламжийн станцын авто баазад Багануур, Налайх, Партизан, Гачуурт, Баянтал, Нисэх, Туул, Сонгино, Хонхорын хүн эмнэлэг, эмнэлгийн ажилчдын амралт, туслах аж ахуйд хэрэглэгдэж байгаа авто машин, тракторын засвар үйлчилгээ,бензин шатахууны нэгдсэн хангамжийг хариуцуулсугай.

9. Зохион байгуулалтын дээрх өөрчлөлтийг энэ оны 4 дүгээр сард багтаан хөдөлмөрчдийн эмнэлэг-ариун цэврийн үйлчилгээг чи-

рэгдүүлэхгүйгээр зохион байгуулах хэрэгжүүлэхийг Улаанбаатар хот дахь эрүүл мэндийн байгууллагуудын дарга, эрхлэгчид, хотын Эрүүл мэндийн газар /н.Буян-Өлзий/, яамны эмнэлгийн тусламжийн бодлогын зөвлөх /н.Бямбаа/-д даалгасугай.

10. Улаанбаатар хотын Эрүүл мэндийн газар /н.Буян-Өлзий/-д ДААЛГАХ НЬ:

а/ улсын үйлчилгээтэй клиникийн нэгдсэн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн аймаг, орон нутагт үйлчилдэг үйл ажиллагааны үндсэн зарчмыг улам боловсронгуй болгон сайжруулах арга хэмжээ авч байх,

б/ хотын дэвсгэрт байгаа улс, хоршоолол, хувийн бүх эмнэлэг урьдчилан сэргийлэх байгууллагуудын санхүү, эд ахуй, үйл ажиллагааны үндсэн тайлан, шуурхай мэдээг 4 дүгээр сарын 1-нээс хүлээн авч нэгтгэн, Эрүүл мэндийн яамны Мэдээлэл тооцооны төвд сар бүрийн 10-нд хүргэх, 1991 оны эхний хагаст багтаан тайлан мэдээг нэгтгэх дүгнэх үйл ажиллагаандаа компьютерийн техник нэвтрүүлэх.

11. 24 цагийн ажиллагаатай эмийн сангуудаар үйлчлүүлж байгаа хүний тоо цөөн, үр ашиггүй ажиллаж байгааг харгалзан эмийн сангуудын ажиллах цагийн хуваарийг хүн амын эмчлэлийн байдалтай уялдуулан тухай бүр зохицуулж байхыг хотын Эрүүл мэндийн газар /н.Буян-Өлзий/, Эмийн сангуудыг удирдах контор /н.Бонхоон/-д зөвшөөрсүгэй.

12. Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагууд иргэдэд эм, эмнэлгийн хэрэгсэл, ялангуяа багаж дутагдалтай байгааг харгалзан зэргэлдээ улс орнуудын хил залгаа хотуудтай худалдаа хийх, харилцан бараа солилцох замаар эм, эмнэлгийн барааны хангамжийг нэмэгдүүлэхийг "Монгол эм импекс" нэгдэл /н.Дашдаваа/, "Эмнэлгийн техник" пүүс /н.Буян/, хотын Эмийн сангуудыг удирдах контор /н.Бонхоон/-д үүрэг болгосугай.

13. Хотын харьяаны эмнэлэг, сувилал, цэцэрлэг, яслийн хүнсний болон угаалга цэвэрлэгээний материал, цагаан

хэрэглэл, хатуу зөөлөн эдлэлийн хангамж муу, өвчтөний хоолны чанар, хүрэлцээ хангалтгүй байгааг харгалзан, нийслэлийн ясли, цэцэрлэг, эмнэлэг, сувиллуудыг дээрх бараа материал бүтээгдэхүүнээр нэгдсэн журмаар хангах асуудлыг боловсруулж, энэ оны II улиралд багтаан шийдвэрлэхийг Эрүүл мэндийн газар /н.Буян-Өлзий/, хотын Хүнсний бараа худалдааны нэгдэл /н.Бадарч/, Аж үйлдвэрийн бараа худалдааны нэгдэл /н.Энхтайван/, Боловсролын газар /н.Чимиддорж/-т үүрэг болгосугай.

I4. Хотын орон сууцны "Өнөр", "Нарлаг", "Баруун хүрээ", хороолол, Шар хад, Амгалан, Дамбадаржаад байгуулах "Эрүүл мэндийн төв"-үүд, IY амаржих газар, хүүхдийн нэгдсэн эмнэлэг болон сүрьеэ, арьс өнгөний төв эмнэлэгт зориулан I99I-I993 онд шинээр барилга бариулах буюу эмнэлэг үйлчилгээг явуулах нөхцөл сайтай барилга шилжүүлэх арга хэмжээ авахыг нэгдүгээр орлогч дарга /н.Ганхуяг/, орлогч дарга /н.Баасанжав, өмчийн газар /н.Найдан/ дэд сайд /н.Гончиг/-д даалгасугай.

I5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан хотын Эрүүл мэндийн байгууллагуудын I99I оны төсөвт зардлыг дахин хянан шийдвэрлэхийг хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны санхүүгийн газар /н.Гонгор/-т даалгасугай.

I6. Энэ тушаал, тогтоол гарсантай холбогдуулан БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах яам, хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны I986 оны 53/70 дугаар тушаал, тогтоолын Ш-2, IX, X-I, XI-4, XII-I,2,3, Эрүүлийг хамгаалах яамны сайдын 1990 оны А/I03 дугаар тушаалын 2 дугаар заалт, 3 дугаар заалтын Найрамдалын районы I,2,3 дугаар хорооны хөдөлмөрчдөд үйлчилж, уг хорооны хөдөлмөрчдөд үйлчилдэг хэсгийн эмч нарыг Найрамдалын районоос Улсын клиникийн II эмнэлэгт төсөв орон тоогоор нь шилжүүлсүгэй гэсэн хэсгийг. Эрүүлийг хамгаалах яам, Зам, тээврийн яам, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны I989 оны А/99/I78/I95 тоот тушаал, тогтоолын 4-а, Эрүүл мэндийн яам, хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны 1990 оны А/I57/260 дугаар тушаал, тогтоолын I,2 дугаар заалтуудыг тус тус хүчингүй болгосугай.

БНМАУ-ЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД П.НЯМДАВАА

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА Л.[redacted]

БНМАУ-ын Эрүүл мэндийн сайд,
Улаанбаатар хотын АХ-ын гүй-
цэтгэх захиргааны 1991 оны
1129/92 тоот тушаал, тогтоолын
нэгдүгээр хавсралт

# УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1. Улаанбаатар хотын Эрүүл мэндийн газар нь Улаанбаатар хотын Ардын хурал түүний гүйцэтгэх захиргаанаас нийслэлийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, бэхжүүлэх талаар баримтлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохицуулан зохион байгуулах, орон нутгийн төрийн захиргааны байгууллага мөн.

2. Эрүүл мэндийн газрын үндсэн зорилт нь нийслэлийн хүн амыг элдэв өвчнөөс анагаах ухааны аргаар урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирын олон хэлбэрийн ажлыг зохион байгуулах, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, хотын дүүрэгт байгаа эмнэлэг, сувилал, эрүүл ахуй, халдвар судлал, яслийн байгууллагын төсөв төлөвлөгөөг зохиох, хянах, санхүүжүүлэх, гүйцэтгэлийг гаргаж тухайн хурлуудад нь тайлагнах ажлыг зохион байгуулж, нийслэлийн иргэдийг эрүүл энх ажиллах, амьдрах өсч хөгжих нөхцөлийг бүрдүүлэх явдал мөн.

3. Эрүүл мэндийн газар нь үйл ажиллагаандаа БНМАУ-ын Үндсэн хууль, Төсвийн эрхийн хууль, БНМАУ-ын эрүүлийг хамгаалах хууль, Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны болон бусад хууль тогтоомж энэ дүрмийг удирдлага болгоно.

4. Эрүүл мэндийн газрыг хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргаанаас томилж, Ардын хурлын чуулганаас батлуулсан дарга удирдан тус газрын үүрэг, зорилтыг хэрэгжүүлэх ажлыг хотын Ардын хурал түүний гүйцэтгэх захиргааны өмнө бүрэн хариуцна.

5. Эрүүл мэндийн газрын үндсэн үүрэг зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг ардчиллын дагуу оновчтой шийдвэрлэхэд зөвлөн туслах үүрэг бүхий даргын зөвлөл ба мэргэжилтний зөвлөлүүд ажиллана.

6. Эрүүл мэндийн газрын дарга эрх хэмжээний асуудлаар холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн тушаал гаргаж, дүрэм заавар батлан биелэлтийг нь зохион байгуулан хангуулна.

7. Эрүүл мэндийн яам, Хотын Ардын хурлын чуулган, гүйцэтгэх захиргаанаас гаргасан эрүүл мэндийн холбогдолтой тушаал,тогтоол, захирамж, дүрэм, зааврыг Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байгаа улс хоршоолол, олон нийтийн байгууллага албан тушаалтан, иргэдэд сурталчлан хэрэгжилт, үр дүнг шалган зааварчилна.

8. Эрүүл мэндийн газрын дарга нь Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргаанаас батлан өгсөн сар, жилийн цалингийн санд багтаан газрын аппаратын ажилтнуудын цалинг тогтоох, аппаратын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх асуудлыг аппаратын ажилтнуудын саналыг харгалзан өөрөө бие даан шийдвэрлэнэ.

9. Эрүүл мэндийн газар нь тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. <u>Эрүүл мэндийн газрын үүрэг, эрх</u>

10. Эрүүл мэндийн газар нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ.

а/ нийслэлийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

б/ нийслэл хотын улс, хоршоолол, олон нийт, засаг захиргааны байгууллагад ажиллагсдынхаа эрүүл мэндийг хамгаалах, ажиллах, амьдрах нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэй сайжруулах ажилд нь зөвлөн туслаж, мэргэжлийн удирдлагаар хангах,

в/ нийслэлийн хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг, үзүүлж болзошгүй хүчин зүйлсийг судлан тогтоож холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх, шаардлагатай зарим асуудлаар зорилтот хөтөлбөр боловсруулж, биелэлтийг нь хангуулах,

г/ нийслэл хотын дэвсгэр нутагт байгаа улс, хоршоолол,хувийн эмнэлэг, эрүүл ахуй, халдвар судлал, эм хангамж, яслийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, материаллаг баазыг бэхжүүлэх, үйл ажиллагааг зохицуулан зохион байгуулж мэргэжлийн хяналт тавих,

д/ Улаанбаатар хотын хэмжээнд эм, эмийн түүхий эд, эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж хэрэгслийн хэрэгцээг тодорхойлон Эрүүл мэндийн яам болон холбогдох байгууллагад захиалан хангуулж байхын зэрэгцээ бие даан экспорт, импортын үйл ажиллагаанд оролцох,

е/ анагаах ухааныг хөгжүүлэх, эмнэлэг, эрүүл ахуй халдвар судлалын тусламж, эм эмнэлгийн барааны үйлдвэрлэлд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх дэвсгэр нутгийн эрүүл мэндийн байгууллагын боловсон хүчнийг захиалга, гэрээгээр бэлтгүүлэх, зөв байрлуулах, мэргэжлийг дээшлүүлэх, орон нутгийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх,

ж/ Улаанбаатар хотын дүүргийн эмнэлэг, сувилал, эрүүл ахуй халдвар судлалын байгууллага, [illegible] аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааны тайлан мэдээг авч нэгтгэн дүгнэлт гаргах, Эрүүл мэндийн яаманд тайлагнах,

з/ хотын хүн ам зүйн бодлого боловсруулж улсын хэмжээний ажилд оролцох,

и/ эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах,

к/ аппаратын болон дэвсгэр нутгийн эрүүлийг хамгаалах байгууллагын эмч, эм зүйч ажилчдыг үр бүтээлтэй ажиллуулах, нийгэм ахуйн нөхцөлийг сайжруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

л нийслэл хотын хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эм, биобэлдмэл, техник хэрэгсэл үйлдвэрлэх, худалдаалах, боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах асуудлаар гадаад улс орны болон нийслэл хотын хамтын ажиллагаатай хотуудын эрх тэгш байгууллагуудтай бие даан хамтран ажиллах,

м/ БНМАУ-ын төсөв эрхийн хуулийн дагуу цалин, эм, хоолноос бусад зардлыг батлагдсан хэмжээнд нь баталсан нэг байгууллагаас нөгөө байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

II. Эрүүл мэндийн газар нь дор дурдсан эрх эдлэнэ:

а/ хүн амын эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон асуудлаар нийслэл хотын дэвсгэрт байгаа улс, хоршоолол, олон нийтийн болон хувийн үйлдвэрийн газар байгууллагын ажлыг шалгаж зөвлөх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах,

б/ нийслэлийн иргэдийн эрүүл мэндийн асуудлаар холбогдол бүхий байгууллага иргэдээс мэдээ, мэдээллийг гаргуулж авах,

в/ Улаанбаатар хотод эрүүл мэндийн нэгж байгууллагыг байгуулах, өргөтгөн өөрчлөх, татан буулгах асуудлыг хамт олон, хөдөлмөрчдийн саналыг үндэслэн Эрүүл мэндийн яамтай тохиролцсоны үндсэн дээр хууль тогтоомжинд заасны дагуу бие даан шийдвэрлэх,

г/ хөдөлмөрийн хамт олны саналыг үндэслэн аппаратын бүтцийн нэгжийг тогтоох, дэвсгэр нутгийн байгууллагын эрх баригчдыг томилж, сарын цалингийн санг тогтоох, төсөв хөрөнгийг хуваарилах эрхийг эдлэнэ. Улсын үйлчилгээтэй байгууллагын захирал, дарга, ерөнхий эмчийг ажилд томилох ба өөрчлөх саналыг Эрүүл мэндийн яаманд тавих;

д/ эмнэлэг, эмийн тусламж үзүүлэх зөвшөөрлийг хоршоо, пүүс, хувь хүнд олгох, үйл ажиллагаанд оролцож, мэргэжлийн хяналт тавих,

е/ дэвсгэр нутгийн эрүүл мэндийн байгууллагын санхүү, төсвийн үйл ажиллагааны зарцуулалтад хяналт тавих, шалгах,

ё/ хууль зүйд нийцээгүй эдлэв зөрчил дутагдлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх, ажиллагсдын нэр төр эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн асуудал боловсруулж тавих эрхтэй,

ж/ эмч, эм зүйч ажилтнуудын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, туршлага судлах, өндөр мэргэжлийн ажилтнуудыг гадаадаас урьж ажиллуулах.

оОо

БНМАУ-ын Эрүүл мэндийн сайд,
Хотын АХ-ын гүйцэтгэх захир-
гааны 1991 оны [illegible]/123 тоот
тушаал, тогтоолын II хавсралт

ТӨВҮҮД /ПОЛИКЛИНИК/-ИЙН АЖИЛЛАХ
ЖУРАМ

Нэг. Нийтлэг журам:

I. Нарийн мэргэжлийн төв, зөвлөх төв, дэвсгэр нутгийн эрүүл мэндийн төвүүд /поликлиник/ нь хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх үндсэн үүрэгтэй эмчлэн сэргийлэх байгууллага мөн.

2. Төвүүд нь тэмдэг, албан бичгийн хуудастай, аж ахуй,санхүү, боловсон хүчин, үйл ажиллагааны хувьд бие даан ажиллана.

3. БНМАУ-ын үндсэн хууль, эрүүл мэндийн хууль, хөдөлмөрийн хууль, улсын үйлдвэрийн хууль, төсвийн эрхийн хууль бусад хууль тогтоомж, энэ журмыг мөрдөж ажиллана.

4. Төвүүдийн эрхлэгчийг Эрүүл мэндийн яам, хотын Эрүүл мэндийн газар хамт олны саналыг судлан үзсэний үндсэн дээр томилно.

5. Өөртөө байгаа мэргэжлээр нутаг дэвсгэрийн зарчмаар урьдчилан сэргийлэх ажил зохиож, эмчлэн эрүүлжүүлнэ.

6. Яаралтай тусламжийг цаг, захиргаа, нас, хүйс, ажлын үйлчилгээний харьяалал харгалзахгүйгээр үзүүлнэ.

7. Боловсон хүчнийг сургах бэлтгэх, мэргэжлийг нь дээшлүүлэх, судалгаа шинжилгээ, сургалтын байгууллагын түшиц болж ажиллана.

8. Нарийн мэргэжлийн тасаг, эмчилгээ, үйлчилгээний кабинетуудын төрөл, тоог Эрүүл мэндийн сайдын 1990 оны А/184 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтыг үндэслэн тогтооно.

Хоёр. Нарийн мэргэжлийн төвийн ажиллах журам

I. Нарийн мэргэжлийн төв Эрүүл мэндийн яамнаас тогтоосон мэргэжлийн чиглэл, бодлогын дагуу хүн амд эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламжийг улсын хэмжээнд үзүүлнэ.

2. Нарийн мэргэжлийн төвийг Эрүүл мэндийн яамнаас томилогдсон захирал удирдаж, цалин тесөвтөө багтааж, нарийн мэргэжлийн кабинет, орон тоогоо өөрөө тогтоож, поликлиник диспансерийн ажиллах журмаар ажиллана.

3. Эрүүл мэндийн яамнаас тогтоосон мэргэжил ба сургах хэмжээ, хугацааны дагуу эмч, сонсогч, оюутан сурагчдын сургалтын бааз болно.

4. Нарийн мэргэжлийн төвд ажиллаж байгаа Анагаах ухааны их сургуулийн тэнхимийн эрхлэгч нар уг мэргэжлээрээ ерөнхий зөвлөхийн үүрэг гүйцэтгэнэ.

5. Тогтоосон мэргэжлийн чиглэлийн дагуу аргачлал, заавар зөвлөмж, гарын авлага материалаар бусад эмнэлгийн байгууллагуудыг хангана.

6. Нарийн мэргэжлийн төв нь Эрүүл мэндийн яамнаас даалгасан буюу эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, Анагаах ухааны их сургуультай зөвшөөрөлцөөний үндсэн дээр даалгаварт буюу уралдаант сэдэв, чиглэлийн дагуу эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх буюу гүйцэтгүүлэхэд туслана.

7. Мэргэжлийн чиглэлээр анагаах ухааны орчин үеийн ололт, шинжлэх ухаан, техникийн дэвшилт аргуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж дэлхийн түвшинд хүрэх зорилттой ажиллана.

8. Аймаг, орон нутагт зөвлөн туслах бригадууд ажиллуулж хөдөөгийн эмч нарын явуулын сургалт семинар зөвлөлгөөн зохион байгуулна.

9. Олон улсын программт ажлуудыг гүйцэтгэх, мэргэжлийн чиглэлээр дэлхийн улс орнууд, адил төстэй үйл ажиллагаатай төв, эм-

нэлэг, институттэй хамтын ажиллагааны гэрээ хэлцэл хийж бие дааж ажиллана.

Гурав. Дүүргийн Эрүүл мэндийн "Зөвлөх төв" дэвсгэр нутгийн "эрүүл мэндийн төв"-ийн ажиллах журам

1. Эрүүл мэндийн "Зөвлөх төв"-ийг Эрүүл мэндийн газраас томилогдсон ерөнхий зохион байгуулагч удирдаж орон тооны бус зөвлөлтэйгээр хот, дүүргийн Ардын хурлын гүйцэтгэх захиргааны удирдлагын дор Эрүүл мэндийн яам, хотын Эрүүл мэндийн газрын бодлого чиглэлийг хэрэгжүүлж ажиллана.

2. Эрүүл мэндийн Зөвлөх төвийн "Нэгдсэн зөвлөл"-ийг дүүргийн нутаг дэвсгэр дэх эрүүл мэндийн байгууллагуудын дарга, ерөнхий эмч, арьс өнөө, сурьеэгийн ерөнхий мэргэжилтэн /хуучин районы диспансерийн эрхлэгч нар/ нарыг оролцуулан, зөвлөх төвийн ерөнхий зохион байгуулагч өөрөө байгуулж ажиллана.

3. Эрүүл мэндийн "Зөвлөх төв" нь дүүргийн эмнэлгүүдийн төсөвт хөрөнгө, орон тоог зохицуулах талаар санал боловсруулна.

4. Зөвлөх болон нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн төв нь хүны өмнө үйлчлэх хүрээний хүн амыг өвчнөөс сэргийлэх хяналт тавих, эмчлэн эрүүлжүүлэхэд үндэслэл болохоор хөдөлмөр, нийгэм ахуй, эрүүл мэндийн дэлгэрэнгүй судалгаа гарган түүнд дүгнэлт хийж, хийх ажлынхаа чиглэлийг гарган авч мөрдөнө.

5. Эрүүл мэндийн зөвлөх төвийн "Ерөнхий зохион байгуулагч" нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн "төв", нарийн мэргэжлийн төв, клиникийн ба нэгдсэн эмнэлэг, ясли, эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын салбар, эмийн сангуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж үр дүнг сар тутам гарган чиглэл өгч, аль нэг байхгүй мэргэшил, оношлогоо эмчилгээний эмч, аппарат, багаж төхөөрөмжөөр тодорхой хуваарь гарган чирэгдэлгүй үйлчлэх нөхцөл бүрдүүлнэ.

6. Дүүргийн эмнэлэг, үйлчилгээний асуудлыг зөвлөх төвийн "нэгдсэн зөвлөл"-ийн гишүүдийн хурлаар хэлэлцэн шийдэх, эсвэл

асуудал боловсруулж холбогдох байгууллагаар шийдвэрлүүлнэ.

7. Дүүргийн амарч хах газрууд, эмнэлгүүдэд жижүүр хийх эмч нарын нэрс, хуваарийг Эрүүл мэндийн зөвлөх төв "Ерөнхий зохион байгуулагч" батлаж, биелэлтийг хянана.

8. Зөвлөх болон нутаг дэвсгэрийн Эрүүл мэндийн төвүүдэд хүүхдийн чих, хамар хоолой, нүд, шүд, мэдрэлийн кабинет ажиллуулна.

9. Зөвлөх болон эрүүл мэндийн төвүүдэд хүүхэд, сэтгэл мэдрэл, сүрьеэ, халдварт, арьс өнгөний эмчийн кабинетыг эмнэлэг халдвар хамгааллын дэглэмийг зөрчихгүйгээр байршуулж ажиллана.

10. Урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх ажлын чанар, үр дүнг сар тутам гаргаж хамт олноороо хэлэлцэж, дүгнэлт хийж ажиллана.

11. Дэвсгэр нутагт байршиж байгаа үйлдвэр, албан газар, айл өрхийн судалгаа гаргаж үйлдвэр, албан газар, цэцэрлэг, ясли, сургуулийн ажиллагсад, сурагч хүүхдийн эрүүл мэндэд хяналт тавьж урьдчилан сэргийлж, эмчлэн эрүүлжүүлж ажиллана.

12. Төвүүд нь өөрсдийн мэргэжлийн чиглэлээр өвчтөнөө хэвтүүлдэг эмнэлэгтэй гэрээ хэлцэл хийж мэргэжлийн эмч нар өвчтөнөө хэвтүүлдэг эмнэлэгт жижүүр хийнэ.

13. Төвүүд өдрийн стационар, гэрийн эмчилгээг өргөтгөж, ачаалал ихтэй кабинетууд, тариа процедур, эмийн фус эмчилгээг ээлжийн ажиллагаатай байлгана.

14. Зөвлөх болон нутаг дэвсгэрийн төвүүд өрх гэр, нутаг дэвсгэрийн зарчмыг баримтлан бригадын системээр ажиллана.

15. Зөвлөх болон нутаг дэвсгэрийн төвүүд нутаг дэвсгэрийнхээ үйлдвэр албан газруудтай ажиллагсдыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах, эрүүлжүүлэх арга хэмжээ авах чиглэлээр гэрээ хэлцэл хийж ажиллана.

16. Төвүүд эмнэлгийн тусламж үзүүлсэн хүмүүсийн бичиг баримтанд тэмдэглэл хийж, акт, магадлагаа олгоно. Хөдөлмөр зохицуулах, рашаан сувиллад явуулах асуудлыг мөрдөж буй заавар журмын дагуу шийднэ.

17. Дүүргийн "Зөвлөх төв", хутаг дэвсгэрийн "Эрүүл мэндийн төв" нь хариуцсан хүн амд урьдчилан сэргийлэх тарилга хийж дархлал тогтцонд хяналт тавина.

18. Хүн амын судалгаан дээр үндэслэн хүн ам зүйн зохистой бодлого, гэр бүл төлөвлөлтийн ажлыг зохион байгуулна.

19. Эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх шаардлага бүхий өвчтөнд /яаралтай бус/ урьдчилан лаборатори, үйл оношийн шинжилгээнүүдийг хийлгэж, холбогдох нарийн мэргэжлийн эмч нартай зөвлөлдсөний үндсэн дээр шийдвэрлэж бичиг баримтыг бүрдүүлж холбогдох эмнэлэгт чирэгдэлгүйгээр хэвтүүлэн эмчилгээний явцад хяналт тавьж, гарахад нь хүлээн авч эмчилгээний үр дүнг стационартай тооцон үнэлэлт дүгнэлт өгч ажиллана.

20. Өөрийн үйлчлэх хүрээний хүн амаас цочмог халдварт болон арьс өнгө, сүрьеэ, бруцеллёз, хавдар зэрэг өвчнөөр өвчилж болзошгүй айл өрх, хүмүүсийн судалгааг гарган урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч үзлэг шинжилгээнд тогтмол оруулж өвчин илэрсэн тохиолдолд тусгай мэргэжлийн кабинетын эмч нарт үзүүлэн оношийг яаралтай тодруулан өвчнийг таслан зогсоох арга хэмжээг авна. Шаардлагатай бол эмч нарин ээлжит бус зөвлөлгөөн хийлгэнэ.

21. Зөвлөх болон эрүүл мэндийн төвүүд нь хэвтэрт байгаа болон өөрөө явж эмнэлгийн тусламж авах боломжгүй өндөр настан, тахир дутуу иргэд, хорт хавдартай болон тархи, нугасны өвчин эмгэгтэй /тархинд цус харвасны дараах үлдэц, нугасны хавдар үрэвслээс болсон тахир дутуу/ хүмүүст гэрээр нь явж үйлчлэх зориулалтын машин, сувилагч, эмч орон тоогоор ажиллуулна.

———oOo———

БНМАУ-ын Эрүүл мэндийн сайд, Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны I99I оны №39/123 тоот тушаал тогтоолын III хавсралт

# УЛААНБААТАР ХОТ ДЭХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ БАЙГУУЛЛАГУУДЫН ШИНЭЧЛЭН ТОГТООСОН НЭРШИЛ

| Хуучин нэрс | Шинэ нэрс |
|---|---|
| I. Улсын клиникийн төв эмнэлэг | - Клиникийн I нэгдсэн эмнэлэг |
| 2. Улсын клиникийн II эмнэлэг | - Клиникийн II нэгдсэн эмнэлэг |
| 3. Улаанбаатар хотын клиникийн төв эмнэлэг | - Клиникийн III нэгдсэн эмнэлэг |
| 4. Ардын армийн клиникийн төв эмнэлэг | - Клиникийн IY нэгдсэн эмнэлэг |
| 5. Эх,хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах эрдэм шинжилгээний улсын нэгдсэн төв | - Эх, нялхсын эрдэм шинжилгээний төв |
| 6. Хавдар судлалын улсын нэгдсэн төв | - Хавдар судлалын төв |
| 7. Сэтгэл мэдрэлийн эмгэг судлалын нэгдсэн төвийн диспансер | - Сэтгэцийн эмгэг судлалын төв |
| 8. Арьс өнгөний эмгэг судлалын улсын нэгдсэн төвийн диспансер | - Арьс өнгөний эмгэг судлалын төв |
| 9. Сүрьеэ уушгины эмгэг судлалын улсын нэгдсэн төвийн диспансер | - Сүрьеэ судлалын төв |
| IO. Халдварт өвчнийг анагаах клиникийн эмнэлгийн халдвартын диспансер | - Халдварт өвчин судлалын төв |
| II. Үйлдвэрийн эмнэлэг,мэргэжлийн өвчний улсын диспансер | - Мэргэжлийн өвчин судлалын төв |
| I2. Монгол эмнэлэг сувиллын төв | - Монгол эмнэлэг-сувиллын төв |
| I3. НАХЯ-ны эмнэлгийн поликлиник | - Эрүүл мэндийн төв № II |
| I4. Төмөр замын эмнэлгийн поликлиник | - Эрүүл мэндийн төв № I2 |
| I5. Стоматологийн поликлиник | - Шүд,эрүү нүүрний эмгэг судлалын төв |
| I6. Эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төв газар | - Эмэгтэйчүүдэд зөвлөх төв |
| I7. Сүхбаатарын районы хүүхдийн нэгдсэн эмнэлгийн поликлиник | - "Сүхбаатар" Эрүүл мэндийн зөвлөх төв |

182



| | | |
|---|---|---|
| 18. Сүхбаатарын районы насанд хүрэгчдийн нэгдсэн эмнэлгийн поликлиник | - | Эрүүл мэндийн төв № I |
| 19. Барилгачдын поликлиник | - | Эрүүл мэндийн төв № 2 |
| 20. IY амбулатори | - | Эрүүл мэндийн төв № 3 |
| 21. Октябрийн дүүргийн насанд хүрэгчдийн нэгдсэн эмнэлгийн поликлиник | - | Эрүүл мэндийн төв № 5 |
| 22. Октябрийн дүүргийн насанд хүрэгчдийн Ш,IY хороолол,дахь амбулатори | - | Эрүүл мэндийн төв № 6 |
| 23. Октябрийн дүүргийн хүүхдийн нэгдсэн эмнэлгийн поликлиник | - | Эрүүл мэндийн төв № 4 |
| 24. Октябрийн районы хүүхдийн нэгдсэн хэсэг /Төмөр замд/ | - | Эрүүл мэндийн төв № 7 |
| 25. Октябрийн районы Баянхушууны хүүхдийн нэгдсэн хэсэг | - | Эрүүл мэндийн төв № 8 |
| 26. Найрамдлын районы насанд хүрэгчдийн нэгдсэн эмнэлгийн поликлиник | - | Эрүүл мэндийн төв № 9 |
| 27. Найрамдлын районы хүүхдийн нэгдсэн эмнэлгийн поликлиник | | |
| 28. Найрамдал дүүргийн нэгдсэн поликлиник | - | Эрүүл мэндийн төв № I0 |
| 29. Ажилчны районы насанд хүрэгчдийн нэгдсэн эмнэлгийн поликлиник | - | "Ажилчин" Эрүүл мэндийн зөвлөх төв |
| 30. Ажилчны районы хүүхдийн нэгдсэн эмнэлгийн поликлиник | | |
| 3I. Ажилчны районы Яармагийн амбулатори | - | Эрүүл мэндийн төв № I3 |
| 32. I амаржих газар | - | I амаржих газар |
| 33. II амаржих газар | - | II амаржих газар |
| 34. Ш амаржих газар | - | Ш амаржих газар |
| 35. Халдварт өвчнийг анагаах клиникийн эмнэлэг | - | Халдварын клиникийн эмнэлэг |
| 36. Гэмтэл согогийн клиникийн эмнэлэг | - | Гэмтэл согогийн клиникийн эмнэлэг |
| 37. Арьс өнгөний эмгэг судлалын нэгдсэн төвийн клиник | - | Арьс өнгөний клиникийн эмнэлэг |
| 38. Сүрьеэ уушгины эмгэг судлалын нэгдсэн төвийн клиник | - | Сүрьеэгийн клиникийн эмнэлэг |
| 39. Уушгины сүрьеэгийн больниц | - | Уушгины сүрьеэгийн эмнэлэг |
| 40. Сэтгэл мэдрэлийн эмгэг судлалын улсын нэгдсэн төвийн клиник | - | Сэтгэцийн эмгэгийн клиникийн эмнэлэг |

| | |
|---|---|
| 41. Найрамдалын районы хүүхдийн нэгдсэн эмнэлэг | - Хүүхдийн нэгдсэн эмнэлэг № I |
| 42. Найрамдалын районы насанд хүрэгчдийн нэгдсэн эмнэлэг | - Нэгдсэн эмнэлэг № I |
| 43. Ажилчны районы хүүхдийн нэгдсэн эмнэлэг | - Хүүхдийн нэгдсэн эмнэлэг № 2 |
| 44. Ажилчны районы насанд хүрэгчдийн нэгдсэн эмнэлэг | - Нэгдсэн эмнэлэг № 2 |
| 45. Октябрийн районы хүүхдийн нэгдсэн эмнэлэг | - Хүүхдийн нэгдсэн эмнэлэг № 3 |
| 46. Октябрийн районы насанд хүрэгчдийн нэгдсэн эмнэлэг | - Нэгдсэн эмнэлэг № 3 |
| 47. Сүхбаатарын районы хүүхдийн нэгдсэн эмнэлэг | - Хүүхдийн нэгдсэн эмнэлэг № 4 |
| 48. Сүхбаатарын районы насанд хүрэгчдийн нэгдсэн эмнэлэг | - Нэгдсэн эмнэлэг № 4 |
| 49. НАХЯ-ны нэгдсэн эмнэлэг | - Нэгдсэн эмнэлэг № 5 |
| 50. Төмөр замын нэгдсэн эмнэлэг | - Нэгдсэн эмнэлэг № 6 |
| 5I. Монгол эмнэлэг сувилалын төвийн клиник | - Монгол эмнэлэг сувилал |
| 52. Элэг цөсний эмгэгийг эмчлэх монгол эмнэлэг | - Элэг цөсний эмгэгийг эмчлэх монгол эмнэлэг |
| 53. Өндөр настны эмнэлэг | - Нөхөн сэргээх эмнэлэг |
| 54. I хорооллын поликлиник | - Эрүүл мэндийн төв № I4 |

**ТАЙЛБАР:** Нэршил өөрчлөгдөөгүй байгууллагууд хуучин нэрээрээ байна. Октябрь, Найрамдал дүүрэгт зөвлөх төвийн үүргийг клиникийн II, III эмнэлгийн поликлиник гүйцэтгэх бөгөөд поликлиник хариуцсан ерөнхий эмч нь клиникийн эмнэлгийн хэ даргад захирагдаж ажиллана.

—— oOo ——

1184

БНМАУ-ын Эрүүл мэндийн сайд, Улаанбаатар хотын АЗ-ын гүйцэтгэх захиргааны 1991 оны 1/19/183 тоот тушаал, тогтоолын II хавсралт

## КЛИНИКИЙН ЭМНЭЛГҮҮДИЙН НАРИЙН МЭРГЭЖЛЭЭР ТӨРӨЛЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ХОТ ХӨДӨӨГИЙН ХӨДӨЛМӨРЧДӨД ҮЙЛЧЛЭХ ХУВААРЬ

I. Клиникийн нэгдсэн төв эмнэлэг:

| | |
|---|---|
| - пульмонологи | - Аймаг хот, Амгалан, Сүхбаатар дүүрэг |
| - эндокринологи /дотор/ /мэс заслын тусламж/ | - Улсын хэмжээнд |
| - гастероэнтерологи /дотор, мэс заслын тусламж/ | - Амгалан, Сүхбаатарын дүүрэг |
| - эрүү нүүрний мэс засал | - улсын хэмжээнд |
| - аллергологи | - -"- |
| - нефрологи | - аймаг, хот, Амгалан, Сүхбаатар |
| - урологи | - улсын хэмжээнд |
| - проктологи | - улсын хэмжээнд |
| - офтальмологи | - аймаг, хот, Сүхбаатар, Амгалан |
| - оториноларингологи | - аймаг, хот, Сүхбаатар, Амгалан |
| - невропатологи | - аймаг, хот, Сүхбаатар, Амгалан |
| - гематологи | - улсын хэмжээнд |
| - кардиологи | - аймаг, хот, Сүхбаатар, Амгалан |
| - Амгалан дүүргийн мэс засал, - эрчимт эмчилгээ | - Сүхбаатар, Амгалан, аймаг, хот |

- Сонгино, Биоүйлдвэр, Гавь-жийн шанд, Налайх дүүрэг хороодын иргэдэд дээрх мэргэжилтнүүдээр тусламж үзүүлнэ.

2. Клиникийн II нэгдсэн эмнэлэг:

| | |
|---|---|
| - кардиологи | - Найрамдал дүүрэг үйлчлэх хүрээний хүн амд |
| - гастероэнтерологи | - -"- |
| - хүүхэд | - үйлчлэх хүрээний хүүхэд |
| - мэс засал | - үйлчлэх хүрээний хүн амд |
| - офтальмологи | - Найрамдал дүүрэг хүн амд |
| - оториноларингологи | - Найрамдал дүүрэг, үйлчлэх хүрээний хүн амд |
| - эндокринологи | - үйлчлэх хүрээний хүн ам |

- нефрологи - үйлчлэх хүрээний хүн ам
- урологи - үйлчлэх хүрээний хүн ам
- мэдрэл - үйлчлэх хүрээний хүн ам
- Гачуурт, Хонхорын хүн амд дээрх мэргэжлүүдээр тусламж үзүүлнэ.

3. Клиникийн Ш нэгдсэн эмнэлэг:

- кардиологи - Октябрийн дүүрэг
- кардиохирурги - улсын хэмжээнд
- невропатологи - Октябрийн дүүрэг
- Нейрохирурги - улсын хэмжээнд
- гастероэнтерологи - Октябрийн дүүрэг
- пульмонологи - Октябрийн дүүрэг
- гематологи - Октябрийн дүүрэг
- нефрологи - Октябрийн дүүрэг
- яаралтай мэс засал - Октябрийн дүүрэг
- Оториноларингологи - Октябрийн дүүрэг
- эрчимт эмчилгээ, сэхээний тасаг - Октябрийн дүүрэг
- нүдний мэс засал - Октябрийн дүүрэг
- Баянтал, Багахангай, Партизан, Багануурын хүн амд дээрх мэргэжлүүдээр эмнэлгийн тусламж үзүүлнэ.

4. Клиникийн IY нэгдсэн эмнэлэг:

- токсикологи - улсын хэмжээнд
- мэс засал - үйлчлэх хүрээний хүн амд
- эрчимт эмчилгээ - үйлчлэх хүрээний хүн амд
- оториноларингологи - үйлчлэх хүрээний хүн амд
- офтальмологи - үйлчлэх хүрээний хүн амд
- нефрологи - үйлчлэх хүрээний хүн амд
- гастероэнтерологи - үйлчлэх хүрээний хүн амд
- невропатологи - үйлчлэх хүрээний хүн амд
- кардиологи - үйлчлэх хүрээний хүн амд
- эрчимт эмчилгээ - үйлчлэх хүрээний хүн амд
- яаралтай мэс засал - Найрамдал дүүрэг

5. Эх нялхсын эрдэм шинжилгээний төв

- мэдрэл - улсын хэмжээнд
- мэс засал - улсын хэмжээнд

- нүд — улсын хэмжээнд
- чих, хамар хоолой — улсын хэмжээнд
- пульмонологи — улсын хэмжээнд
- эндокринологи — улсын хэмжээнд
- гематологи — улсын хэмжээнд
- нефрологи — улсын хэмжээнд
- урологи — улсын хэмжээнд
- кардиологи — улсын хэмжээнд
- гастроэнтериологи — улсын хэмжээнд
- дутуу төрөлт — улсын хэмжээнд
- охид — улсын хэмжээнд
- сексопатологи — улсын хэмжээнд
- дерматологи — улсын хэмжээнд
- эмэгтэйчүүдийн бичил мэс засал — улсын хэмжээнд
- удамшил-генетик — улсын хэмжээнд

ТАЙЛБАР:

- улсын хэмжээнд хариуцсан төрөлжсөн нарийн мэргэжлээс бусад нарийн мэргэжлээр Дархан, Эрдэнэт хот, аймгуудын өвчтөнг клиникийн эмнэлэгт шинжүүлэх тохиолдолд хөдөлмөрчин хүний саналыг харгалзан, клиникийн I,II,III эмнэлгийн аль дуртайд нь илгээнэ.

- Хэрэв хот, хөдөөгийн хөдөлмөрчид өөрөө хүсвэл дуртай эмнэлэг, эмчдээ ачааллыг нь харгалзан үзүүлж үйлчлүүлнэ.

―――――оОо―――――

188

БНМАУ-ын Эрүүл мэндийн сайд,
хотын АХ-ын гүйцэтгэх захир-
гааны I99I оны [illegible] тоот
тушаал, тогтоолын I хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН НУТАГ ДЭВСГЭРТ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ БАРЬЖ БАЙРШУУЛА-
ХАД БАРИМТЛАХ ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН,
НОРМАТИВ ҮЗҮҮЛЭЛТ

I. Гэр хорооллын I0,0 мянган хүн амд ээлжиндээ 300 хүнд үйлчлэх хүчин чадалтай нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн төвийг 4 км радиуст үйлчлэхээр барина.Тус төвд IY зэргийн эмийн сан, нян судлалын лаборатори, ариутгал, халдваргүйтгэлийн тасаг бүхий эрүүл ахуй, халдвар судлалын II зэргийн төв, бие бялдар чийрэгжилтийн цогцолбор багтана.

2. Орон сууцны хорооллын 30,0-40,0 мянган хүн амд ээлжиндээ 900 хүнд үйлчлэх хүчин чадалтай нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн төвийг дунджаар 2 км-ийн радиуст үйлчлэхээр барина.

Тус төвд III зэргийн эмийн сан, Эрүүл ахуй, халдвар судлалын I зэргийн төв, бие бялдар чийрэгжилтийн цогцолбор багтана.

_______оОо_______